

А. Дамдинсүрэн

МАОГИЙНХАН АРХЕОЛОГИЙН БАРИМТЫГ ГУЙВУУЛЖ БАЙГАА НЬ

Бээжингийн суртал нэвтрүүлэгчид баталж өгүүлэхдээ «соёлын хувьсгал» нь Хятадад түүхийн шинжлэх ухаан, юуны өмнө археологи судлалын ажлыг онцгой шинэ дээд шатанд гарган хөгжүүлсэн юм гэж сайрхан зарлаж байна.

Тэгээд ч хятадын маоист эрх баригчид нь эрт урьдын цагт хятадад хамаарагдаж байгаагүй хятад биш үндэс угсааны ард түмний үндсэн нутаг дэвсгэр дээр буй эртний булш бунхан ухаж, эд юмыг олзворлоход онцгой анхаарал тавьдаг болсон юм.

1971 оны эцэс-1972 оны эхээр «Хятадын археологийн амжилтыг» сурталчлах өргөн олон түмнийг хамарсан кампанит ажил гэгчийг хятад орон даяар өрнүүлэв. Энэ кампанит ажлаар олсон олдворын зүйлдээ түүхийн бодит үнэнийг илэрхий мушгин гуйвуулсан тайлбар дүгнэлт хийж «Жэньминь жибао» сонин, «Каогу» (археологи) сэтгүүл «Вэньу; (эдийн соёл) сэтгүүл, гадаадын уншигчдад зориулан гаргадаг «Хятад улс» гэдэг зурагт сэтгүүл болон радио нэвтрүүлэг зэрэг олон хэлбэрээр сурталчилж байна. Энэ кампанит ажлын үндсэн зорилго нь жинхэнэ шинжлэх ухааны үндсэн дээр явуулдаг археологи судлалтай огт хавьтахгүй, харин хятадын эрх баригчдаас хөрш зэргэлдээ улс орнуудаа түрэмгийлэн нэгтгэхэд чиглэгдсэн харгис бодлогоо «түүхийн үндэстэй» болгож, зөвтгөн цагаатгахад оршиж байна.

Хятадын зарим түүхчид ийнхүү маоист эрх баригчдын явуулж байгаа их гүрний жанжлах дээрэнгүй гадаад, дотоод бодлогод захирагдаж өнө эртнээс эхлэн Хятадтай айл зэргэлдээ оршин нутаглаж ирсэн улс орнуудын нутагт өнгөлзөн шунахдаа Цинь, Хан улсын үед Цагаан хэрмийн араар нутаглаж байсан хятад биш хүннү зэрэг нүүдэлчин олон улс аймгууд нь Хятадын Цинь, Хан улсын харьяаны цөөн тоот, үндэстэн байсан мэтээр бичиж, Төв Азийн нүүдэлчдийн анхны төр улсыг байгуулсан хүннү зэрэг янз бүрийн улс угсаатны түүхийг илэрхий басамжлан гуйвуулж байна. Энэ тухай БНХАУ-д нийтэлсэн сүүлийн үеийн зарим баримтаас авч үзье.

Өвөр Монголын бичиг дурсгалын зүйлийг судлах газар, Өвөр Монголын музейгээс хамтран найруулж бичсэн «Өвөр Монголын автономит районы бичиг дурсгалын зүйлийг судлах археологийн ажлын их амжилт» гэдэг өгүүллийг Вэньу (эдийн соёл) сэтгүүлийн 1977 оны 5-рт «Манай улсын түүхийг олон үндэстний ард түмэн нийтээр бүтээсэн юм гэдгийг Өвөр Монгол районоос олдож буй археологийн баялаг материал маргашгүй харуулж байна. Өвөр Монголын нутагт удаа дараалан (урьд хожид) оршин амьдарч байсан манай улсын эртний ах дүү үндэстэн Хүннү, Ухан, Сяньби, Жужан, Түрэг, Уйгар, Кидан, Зөрчид Монгол, Манж зэрэг үндэстэн хан үндэстэнтэй хамтаар Өвөр Монголын уудам дэлгэр нутгийг эзэмшиж байсан юм. Манай улсын эдгээр үндэстний өвөг дээдэс бол Өвөр Монголын газар нутгийн жинхэнэ эзэд нь мөн.

Манай улс нь Цинь, Хангийн үеэс хан үндэстэн дийлэнх олонхи нь болсон олон үндэстний харьцангуй тогтвортой улс болон бүрэлдсэн бөгөөд ах дүү олон үндэстэн нь хан үндэстэнтэй нягтран нэгдсэнийг Өвөр Монгол нутгаас олдсон олдвор, түүхийн янз бүрийн үед энд байсан үндэстнүүдийн үлдээсэн соёлын ба эдийн дурсгалаас тодорхой харж болно. «Цагаан хэрмээр зааглагдан таслагдаж хэзээ ч байгаагүй». Энэ бодит баримт нь Зөвлөлтийн ревизионист шинэ цагаан хааны «Хятадын хойт хил хязгаар нь цагаан хэрэм» гэдэг буруу номлолыг бас дахин илчлэв»¹ гэх мэтээр бичжээ. Гэвч чухамхүү Цинь, Хан улсын үеэс цагаан хэрэм нь Хятадын умард хил хязгаар болсоор байсан тухай дэлхий дахины соёлт улс орнуудын түүх сударт нэгэнт тэмдэглэгджээ.

Хятадын цагаан хэрмийг анх эртний Хятадын Долоон улсын Ян, Чжоу Цинь гурван улс умардын хөрш хүчирхэг нүүдэлчидтэй хил залгаа ахуй цагтаа өөрийн умард хилийн цайз бэхлэлт болгон анх барьж, тэнд хил хамгаалах цэргийн анги суулгасан байна.

Тан улсын (МЗ 618—91) үед хятадын хаад умардын нүүдэлчин Түрэг, Кидан зэрэг улс аймгуудын довтолгооноос хамгаалж цагаан хэрмэнд цэрэг байнга суулгаж, хэрэм барих ажлыг үргэлжлүүлэн хийж байжээ.

Юан улсын үед ч гэсэн (1260 - 1368) цагаан хэрмийн ар талын нутаг нь Монгол нутаг хэвээр байсан бөгөөд хятад нутгийн умард хил нь мөн л цагаан хэрмээр хиллэж байжээ. Үүний нэг тод томруун баримт нь Монголын Юан улсын хаан Тогоонтөмөр 1345 оны үед зарлиг буулган Цагаан хэрмийн цавчаал боомтын (Цзюи Юн-гуан) хананд санскрит төвд, монгол, уйгур, хятад, тангад зэрэг зургаан хэл дээр бичиг сийлүүлж бүддийн шашны номын ёсоор хил хязгаар, үүд хаалга манадаг бурханы хөргийг сийлүүлсэн нь одоо хүртэл хэвээр хадгалагдаж байна.

Мин улсын үед хятад нь умард хил хязгаараа батлан хамгаалах талаар онцгой анхаарч, цагаан хэрмийн дагуу 9 боомтонд цэрэг суулган Бээжингээс хөөгдсөн монгол хаад хүчээ бөөгнөрүүлэн дахин довтолж магадгүй гэж ихэд айн болгоомжилж цагаан хэрмийг засаж сэлбэх ажлыг хийж байсан ажээ.

Манж Чин улсын үеийн хуульд хятад хүн цагаан хэрмээс хойш гарч болохгүй хуультай байсан юм.

Гэтэл хятадын түүхчид, археологчид цагаан хэрмийн араар олон үеийн турш хятадтай айл хөрш, улс төр, эдийн засаг, соёлын талаар харилцаатай явж ирсэн хятад биш улс аймгуудыг тэр үед хятадын цөөн тоот үндэстэн болж байсан мэтээр бичиж байна. Тэгвэл дээрх умардын Хүннү тэргүүтэй олон улс аймгууд Цинь, Хан улсын харьяанд байсан юм бол Хятадыг тэдгээр олон нүүдэлчдээс тусгаарласан цагаан хэрмийг юунд барьж байсан юм бэ? гэдэг асуудал аяндаа гарч ирэх болно.

Одоогийн Өвөр Монголын районд хятад биш нүүдэлчин олон улс аймгууд нэн эрт цагаас эхлэн амьдарч соёл иргэншлээ цогцлуулан хөгжүүлж байсан зэргийн учир нүүдэлчдийн соёлын амжилт Хятадад олон талаар нөлөөлж ул мөрөө үлдээсэн нь одоо хүртэл уламжлагдан иржээ. Цагаан хэрмийн араас хятадын археологчдод нүүдэлчдийн соёлын түүхэнд холбогдох ховор нандин дурсгалууд олон тоогоор олдож буй явдал Үүнийг гэрчилж байна.

Хятад түүхч Тянь Гуан-цин гэгч «Өвөр Монголын Зүүнгар хошууны Уйлантай дахь Хүннүгийн булш» гэдэг өгүүлэл бичиж Хятадын ШУА ийн хэвлэл «Каогу» сэтгүүлийн 1977 оны № 2-т нийтлүүлжээ. Зохиогч

1. «Вэньу» сэтгүүл. Бээжин, 1977, № 5. 6-р тал

Өвөр Монголын Их зуу аймгийн (хуучин зургаар) Зүүнгар хошууны хойт хэсэгт байдаг уйлантай гэдэг газар дахь Хүннүгийн булшнаас Хүннү нарын эдэлж хэрэглэж байсан хүрэл хутга зэрэг нилээд эд агуурсын зүйлийг ухаж олсон тухай нийтлүүлсэн өгүүллийнхээ эцэст дүгнэлт болгож «Тэр үед эл газар районд нутаглаж байсан Хүннү үндэстэн бол манай улсын эртний цөөн тоот үндэстний нэг байсан юм гэдгийг дээр дурдсан баримт харуулж байна»² гэх зэргээр түүхийг завхруулсан байна.

Хүннү бол түүхийн ямар ч үед хятадын цөөн тоот үндэстэн нь болж байгаагүй, хүннү нар нь өөрийн гарал үүсэл, түүх, ахуй амьдрал, зан заншил, хэл, соёл иргэншлийн хувьд хятадтай огт хавьтахгүй эрс тэс өөр, эрт дээр үеэс эхлэн тулгар төр улс байгуулан оршин нутаглаж ирсэн өөрийн уугуул нутаг дэвсгэр, хил хязгаар бүхий нүүдэлчин улс байсан юм. Бид Хүннү нарын түүхийг ингэж дур зоргоороо гүтгэн гуйвуулж байгаа явдлыг залруулж өнгөрсөнөөс өнөө хүртэл уламжилж ирсэн хүннүгийн түүхийн бодит баримтуудын заримаас хойно дурдсугай.

Манай эрний өмнөх III зууны сүүлчээр одоогийн монгол нутагт хүннү аймгуудыг нэгтгэсэн хүчирхэг улс байгуулагджээ. Түүнийг үндэслэгч нь Түмэн Шаньюйн хүү Модун (209—176) байжээ. Модун эцэг Түмэнгийн Хятадад алдсан Ордос нутгийг эгүүлэн авчээ.

Модунгийн үед хүннү нарын улс маш хүчжиж умар, өмнийн нүүдэлчин олон аймгийг номхотгоод, Хүннү улс Хятад улстай эн сацуу болов гэж Хятадын сударч түшмэл бичжээ.³ Манай эрний өмнөх 200 онд Модун Шаньюй (хаан) хятадын довтлон ирсэн 300000 цэргийг бутцохиж, Хан улсын хаан Гао Ди-ийг (206—194) Пинчин хот (одоогийн Датун) орчим 7 хоног бүслэн хаажээ. Хан улсын хаан арга буюу ялагдсанаа хүлээж, 198 онд хүннү улстай найрамдлын гэрээ байгуулжээ.

Энэ гэрээгээр хятадын Хан улс жил бүр шаньюйд алт, магнаг торго, тариа будаагаар алба барих үүрэгтэй болж байсан юм. Ийнхүү Хан улс 50-иад жилийн турш Хүннүд алба барьж явжээ.

Модун шаньюйн үед түүний улсын нутаг дэвсгэр нь өмнө зүг цагаан хэрэм, ордос нутаг, умар зүгт Сэлэнгэ мөрний доод урсгал, баруун зүгт ил тарвагатай, Синьцзян, дорно зүгт Хойт Солонгос хүртэл уудам их болжээ. Тэр үед улсын бүх газар нутаг нь хүннүгийн хаан Шаньюйн мэдэлд харьяалагдаж байжээ.

Модун бүх нутгаа зүүн, баруун, төв гэж гурван хэсэг хувааснаас гадна аравт, зуут, мянгат, түмт гэж цэрэг захиргааны зохион байгуулалтыг хийжээ. Хаан Шаньюйн шадар түшмэлүүд нь цэрэг-засаг захиргааны том хэсгүүдийг удирдаж тус бүрдээ дээд тал нь 10000 хүртэл цэрэг захирч байжээ. Дээд тушаалд томилогдсон эдгээр түшмэлийн цэрэг, ардын нутаглах газрыг шаньюй заан өгдөг байжээ. Улсын төв хэсгийг Модун шаньюй өөрөө захирч, зүүн, баруун гарт нижгээд ванг томилон захируулжээ.

Хүннү улсын төр, хааны орд өргөө нь тус улсын Орхон Туулын сав газарт байжээ.⁴ Модун нь аймгуудын зонхилогчид, язгууртан нарыг шууд баримтлан захирах болж, улмаар улсын зүүн ван, баруун ван нарыг томилон мөн улс байгуулахын өмнө хүннү аймгийн холбоог бүрдүүлж байсан аймгуудын зонхилогч нарыг тус бүр түмтийн ноён болгох зэргээр ноёдын шинэ зэрэг дэвийг бий болгожээ. Түүнчлэн м.э.ө. 174—163 онд

2. «Каогу», 1977, № 2.

3. «Гу Вэньюань жян» хэмээх утга уянгын бичиг, 5-р дэвтэр. Юмжавын орчуулга. Улсын номын санд бий.

нийт улс даяар албан татварыг харьцангуй эмх цэгцтэй, нарийн журамтай болгож, жинхэнэ хүннү иргэдийн хүн ам, мал хөрөнгөний тоо толгойд татвар ноогдуулан авах журам тогтоон явуулсан байна. Зарим эрдэмтдийн үзэж байгаагаар Хүннү гүрэн ид мандан байх үедээ хожмын орхоны түрэг бичгийн эх болох «рунь» маягийн авианы дуудлага бүхий бичиг үсгийг анх бий болгон хэрэглэж байсан гэдэг таамнал бас бий.

Хүннү нар мал аж ахуйг голлон эрхлэхийн хамт ан гөрөө, мөн газар тариалан, гар үйлдвэр хөгжүүлэхийг оролдож байв. Үүнийг археологийн олдворууд баталж байгаа юм. Бас хүннү нарын дунд балгас суурин удаа дараалан байгуулагдаж, заримд нь гар үйлдвэр дэлгэрч, төмрийн хүдэр хайлж төмөрлөг боловсруулж байсан байна. Хүннү зэргэлдээ аймгуудтайгаа арилжаа наймаа хийхийн хамт Дундад Ази, Хятад зэрэг улс орнуудтай худалдааны харилцаа бүхий болж, мал аж ахуйгаас гарах түүхий эд, ангийн үслэг, мөн гар үйлдвэрийн зарим бүтээгдэхүүнийг арилжих ажил хүннүгийн аж ахуй, эдийн засагт чухал байр суурийг эзэлж байсан байна⁵

Иймд хүннү гүрэн бүрэлдэн тогтсон явдал бол Төв Азийн малчин аймгуудын дотор анги бүрэлдэх явц зарим талаар лавширсныг гэрчлэхээс гадна хүннү нарын дунд нийгэм, төр, эдийн засгийн үлэмж өөрчлөлт гарсныг харуулж байна.

Хятадын хан улсын умардад түмэн газрын цагаан хэрмийн араар нутаглаж байсан нүүдэлчин олон овог аймгууд нэгдэн нийлж Хүннү гүрнийг бүрэлдүүлэн байгуулж, соёл иргэншил нь өөдлөн хөгжиж байсан явдал нь хан улсын У Ди зэрэг хаадын санаанд үл нийцэх зүйл болжээ. Учир иймд Хятадын хаад ноёд «дөрвөн зүгийн зэрлэгүүдээс» хан улстай зэргэцэх улс гарч болохгүй гэж үзээд, Хүннүг устган хөнөөх талаар ил далд олон зүйлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах замд орсон юм. Хан улсын хаад нь нэн түрүүнд Хүннүгийн язгууртанд эд бэлэг өгөх, ургийн холбоо байгуулах замаар биедээ алгуурхан татахдаа Хүннүгийн язгууртны дотор өөрийн төлөөний этгээдийг буй болгож, түүгээр дамжуулан Хүннүгийн дотоодод хагарал тэмцлийг зориуд үүсгэж эв нэгдлийг нь хагалан бутаргахын хамт хүннү нарыг тэдний холбоотноос нь салгах, бас хүннү нарын эрх мэдлээс гарахыг оролдож байсан аймгуудыг тухирах бодлогыг хүчтэй явуулжээ. Жишээ нь м.э.ө. 140-86 он хүртэл хан улсын төр барьсан У Ди хааны үед Хүннүг ганцаардуулан устгах нарийн боловсруулсан бодлогыг гурван чиглэлээр явуулжээ. Түүний нэгдүгээр нь Хүннүг ордос нутгаас хойш хөөн гаргаж, өмнө захын үржил шимтэй нутгаас хөөжээ. 2-р нь Хан улс Хүннүгийн зүүн хөрш Солонгосыг дайлж Хүннү Солонгосын хооронд хэдэн халхавч газрыг байгуулж, Хүннү гүрний зүүн хэсгийг тасалжээ. Энэ тухай «түүний сайн өн тариаланг булаавай»⁶ гэж хан улсын нэгэн сайд хаандаа айлтгаж байснаас үзэхэд хүннү нарыг тариалангийн гол нутгаас нь салгасан байна. 3-р нь Хан улс Хүннүгийн баруун тал Фергана хавийн Давань улсыг эзэлж, Дорнод Туркестаныг дайлж, Усуныг довтолж, Хүннү улсын баруун хэсгийг бас тасалжээ. Энэ бодлогын үр дүнд «Хүннү сая ганцаар болоод говиос хойш газарт хол зайлж, дөрвөн хязгаарт хэрэггүй болов»⁷ гэж мөнхүү сайд айлтгалдаа бичжээ. Хан улс ийнхүү Хүннүгийн эсрэг олон арван жилийн турш хэдэн зуун мянган цэргээр тасралтгүй довтолж хүн амыг үй олноор нь хөнөөж амьд үлдэгсдийн ихээхэн хэсгийг олзолж аваачихын хамт мал хөрөнгө, эд материалын асар их хохирол учруулсаар иржээ. Энэ нь Хүннүгийн хэвийн байдлаар оршин тогтноход ноцтой занал учруулж байсан юм. Үүгээр зог-

4. БНМАУ-ын түүх, боть I, (гурван боть), УБ, 1966, 84-р тал.

5. БНМАУ-ын түүх, боть I, (гурван боть) УБ., 1966, 1966, 90-р тал

6. Лю Синь сайды найлтгал, Гүвэнь юаньжан бичиг, 16-р дэвтэр.

7. Мөн тэнд.

сохгүй Хан улс нь Хүннүг цаашдаа бүрмөсөн устгах бодлого явуулсан учир Хүннүгийн зарим хэсэг нь манай эрний 1-р зууны үед монгол нутгаа орхиж баруун тийш нүүдэллэн Дундад Ази, Европт очиж суурьшсан юм. Гэвч Хүннүгийн дийлэнх гол төлөв нь монгол нутагтаа үлдсэн билээ. Хан улс Хүннүгийн 200000 гаруй хүнийг удаа дараагийн довтолгооноороо олзлон аваачсан хийгээд баруун зүг нүүсэн хүннү нарыг хасахад Монгол нутагт нэг сая орчим хүн ам бүхий Хүннү улс тогтнон үлдсэн байна. Хүннү нарыг баруун Европт нүүдэллэсэн тухай хятадын түүхч Ди Сы-хэ бичсэн өгүүлэлдээ: «Манай эрний өмнө 91 онд Умарт Хүннү баруун тийш нүүдэллэхэд 100 мянган өрх бүхий 600 мянган хүннү нар язгуур (товийн хойно) нутагтаа үлдсэн юм»⁸ гэжээ.

Түүхийн баримт материалд тулгуурлаж үзвэл энэ тоог бараг нэг дахин багасгаж гаргасан ажээ. Тэр үед хүннү нарын өрх 200000-аас доошгүй, хүн ам нь лавтайяа нэг сая гаруй байсан ажгуу. Хүннү нарын дийлэнх ихэнх нь БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр үеийн үед аж төрөн оршин амьдарсаар байсан түүхтэй. Үүний нэг тод баталгаа бол Хүннү улсын үед түүний нутаг дэвсгэр гэдэг ойлголтонд багтаж, хүннү нарын оршин нутаглаж аж төрөн амьдарч байсан ул мөр нь сүүлийн жилүүдэд гадаад дотоодын археологчдоос удаа дараалан явуулсан шинжилгээгээр хүннү намрын янз бүрийн дурсгалууд олон тоогоор олдож түүний оршин тогтнож байсан он цагийг нарийн тогтоох бололцоог олгож байгаа юм. Археологчдын судалгаагаар зөвхөн манай оронд Хүннүгийн 100 гаруй булш нэгэнт илрэн олдоод байгаа юм.

Хүннү түүнчлэн Дунху нарын удам угсаа манай эриний VI зуун хүртэл Сяньби, У хан, Моюун, Жужан, Тоба гэх зэрэг янз бүрийн нэрээр түүх сударт тэмдэглэгдэн явсан байна.

Нөгөөтэйгүүр, саяхан Хятадын түүхчин Ци Сы-хэ, хүннүгийн гарлын талаар хятадын хуучин сурвалж бичигт тулгуурлаж бичихдээ: «Хүннү бол эрт цагаас нэрд гарсан нүүдэлчин үндэстэн бөгөөд урт удаан хугацааны турш манай улсын умард тал нутгаар амьдарч байсан юм.⁹ Барагцаалбал «Мэе 1401—1122 оны үеэс эхлэн хүннү нарын тухай тэмдэглэгдэх болсон юм¹⁰ гэж тэр бичээд цааш хүннү нарын бие бялдар антропологийн онцлогийг судалж хүннү нар нь монгол хүнтэй адил¹¹ гэж нотолжээ. Ци Сы-хэ ингэж хүннү хятадтай хавьтахгүй, харин монгол үндэс угсааны улс байсан гэдгийг зөвшөөрөн хүлээжээ.

Түүнээс гадна Европт нүүж очсон хүннү нарын булшнаас олдсон хүннү хүний антропологийн дурсгалыг өрнөдийн эрдэмтэд харцуулах судалж монгол хүнийхтэй адил гэж тогтоож байсан явдал хүннүг монголын өвөг дээдсийн нэг байж болохыг давхар баталж байна. «1926—1929 онд эрдэмтэн N. Fettich, L. Bartucs нарын явуулсан судалгаагаар Унгарын Mosonszentjanos дахь «хүннү-авар» булшнаас хүннү нарын яс маш олныг олжээ. Энэхүү олдворыг антропологийн аргаар судалж үзэхэд уг хүний биеийн өндөр нам, толгойн хэлбэр болон хоёр хөмсгөний тойргийн хэмжээ, нүдний ухархайн хэмжээ, хамрын угийн гол дунд дахь цэг, хамарны яс, соёоны хонхор, хацарын яс, хамар дорхи хонхорхойн (хүн хон хорхой) онцлог болон үсний шулуун байдал, гээг үсний хар гялгар өнгө зэргээс үзэхэд хүннү нар нь зөвхөн монгол хэлбэрийн хүмүүс байснаар барахгүй, лавтай Монгол хүн байсан гэдгийг бид зөвшөөрч байна»¹² гэж

8. Лиши яньцзю. Бээжин, 1977 он. № 3.

9. Лиши яньцзю, 1977, № 3, 127-р тал. Бээжин.

10. Мөн сэтгүүл, 127-р тал

11. Мөн сэтгүүл, 135-р тал.

12. L. Bartucs. 1929, über die anthropologischen Ergebnisse der Ausgrabungen von Mosonszentjanos, ungarisch (skythica 11. Prague)

бичжээ. Үүнээс гадна профессор Weringer нь уг булшнаас гарсан хүннүгийн ясыг судлан үзэж монгол хүнийхтэй ижил гэж тогтоожээ.¹³

Хүннү, хан улс хоёр нь хэн хэндээ үл захирагдан эрх тэгш оршиж ирсэн түүхтэй. Маогийнхнаас түүх, археологийн баримтыг бүдүүлгээр гуйвуулан завхруулж байгаатай уялдуулж анхаарууштай нэгэн зүйл бол даруй хүннү, хятадын хооронд МЭӨ 198 онд байгуулсан гэрээний эх бичигт «Цагаан хэрмээс хойшхи нум агсагчдын улс нь шаньюйн зарлигийг дагаж, цагаан хэрмээс урагших түшмэдийн дээл, малгай өмсөгчдийн улс нь харин надад захирагдана...хан улс, хүннү хоёр бол мөр зэргэцэх хүчирхэг улсууд юм»¹⁴ гэж өгүүлсэн явдал мөн. Энэхүү баримтаас үзэхэд хүннү нар хятадын цөөн тоот үндэстэн нь болж байсан биш, харин биеэ даасан тусгаар улс гүрэн байсан нь тов тодорхой харагдаж байна.

Хятадын одоогийн маоист түүхчдээс улс үндэстний эртний уг гарал түүхийг санааны дураар гуйвуулахыг оролдож байгаа нь нэг ёсондоо айх хөрш орших хятад биш ард түмнийг түрэмгийлэх гэсэн оролдлого мөн.

13. Y. Greguss: Dolgozatok. vol. 1927. Werner (ESA. VII. 1932).

Хүннүгийн түүхийн стдалгаа. p. 187, 192.

14. БНМАУ-ын түүх, тэргүүн боть, УБ., 1966, 83-р тал.

Н. Я, Бичурин, Собрание сведений о народах, обитавших в Средней Азии и древние времена, т. 1, с. 59-60.